

УЛС ТӨР,
ОЛОН УЛСЫН ХАРИЛЦАА

**БНАСАУ-ЫН 40 ЖИЛИЙН
ТҮҮХЭН ЗАМНАЛ,
БНМАУ-БНАСАУ-ЫН
ХАРИЛЦАА**

Ж. СҮХЭЭ

Манай ард түмэн найрамдалт солонгосын ард түмний их баяр- БНАСАУ байгуулагдсаны түүхт 40 жилийн ойг ёслол төгөлдөр тэмдэглэв. Солонгосын хойгт оршин тогтнож байсан хамгийн эртний төр улс нь Чосон юм. Энэ нь манай эриний өмнөх V—IV зуунд ихээхэн хөгжсөн улс байжээ. Манай эриний эхний зуунуудад Солонгосын хойгт Когурё, Пэкче, Силла гэсэн эртний феодалын улсууд үүсч оршин тогтнож байгаад X зууны эцсээр Солонгосын хойгийг бүхэлд нь нэгтгэсэн Корё улс байгуулагдсан. Энэ үеэс Солонгосыг европчууд «Корей» гэж нэрлэх болсон гэж үздэг бөгөөд дорно дахины зарим бичиг сударт «гуулин улс» гэж гарна. «Монголын нууц товчоо»-нд гардаг «Солонгос» гэдэг үгийн гарлыг эрдэмтэд янз бүрээр тайлбарладаг. Монгол хэлний «Солонго» гэдэг үгнээс үүсэлтэй, одоо солонгос хүүхдийн үндэсний хувцас ны ханцуйг солонгын хурц өнгөөр ялган хийсэн байдаг зэрэг баримтыг иш үндэс болгодог юм.

Дундад зууны үед солонгосын ард түмэн харийн булаан эзлэгчдийн эсрэг нэг бус удаа зэвсэг барин тэмцэж байсан түүхтэй. Япон улс 1876 онд Солонгост анхны тэгш бус худалдааны хэлэлцээрийг тулган хүлээлгэсэн бөгөөд 1905 оны арваннэгдүгээр сард Солонгост өөрийн захиргааг тогтоож, улмаар 1910 онд «Солонгосыг нийлүүлэх тухай гэрээ» байгуулж түүнийг Япон улсын нэг муж гэж зарлажээ. Тэр цагаас хойш Солонгос орон 1945 оны наймдугаар сар хүртэл 35 жилийн турш Японы ноёрхолд байв.

ЗХУ Европт фашист Германыг бутцохисны дараа гитлерийн эсрэг эвслийн холбоотон гүрнүүдтэй тохиролцсоны дагуу 1945 оны наймдугаар сард милитарист Японы эсрэг дайн зарлаж, улмаар 20 гаруйхан хоногийн дотор японы цохилтын гол хүч сая гаруй цэрэгтэй Квантуны армийг бутцохисноор Солонгос орон Японы колонийн дарлалаас чөлөөлөгдсөн юм. Чөлөөлөгдсөн үеэс Солонгос орон даяар ардын ардчилсан хувьсгалын үйл явц өрнөж эхэлсэн боловч тус орны бүх нутгийн хэмжээнд энэ хувьсгал ялалтад хүрч чадаагүй юм.

Зөвлөлтийн арми Солонгосын партизануудын хамтаар тус орныг Японы ноёрхлоос чөлөөлсөн боловч Солонгос дахь Японы цэргийг буулгаж авах ажлыг дэлхийн хоёрдугаар дайнд гитлерийн Германы эсрэг холбоотон байсны хувьд ЗХУ, АНУ хоёр хамтран хариуцаж гүйцэтгэхээр тохиролцсон юм. Үүний дагуу АНУ 1945 оны есдүгээр сард Солонгосын нутгийн өмнөд хэсэгт цэрэг оруулжээ. Ийнхүү Солонгос дахь Японы армийг буулган авч, колонийн засаг захиргааг устгаж, улмаар Солонгосын төв засгийн газрыг байгуулах хүртэл түр хугацаагаар тус улсын умард хэсэг Зөвлөлтийн цэргийн командлал, өмнөд хэсэг америкийн цэргийн командлалын хяналтад орших ёстой байв.

1945 оны арван хоёрдугаар сард Москва хотноо болсон ЗХУ, АНУ, Их Британы ГЯЯ-ны сайд нарын зөвлөлгөөнөөр Солонгос нь нэгдмэл, тусгаар тогтносон, ардчилсан улс байх ёстойг хүлээн зөвшөөрч, Солонгосын түр засгийн газрыг байгуулах нь зүйтэй гэж тохиролцсон юм. Гэвч америкийн цэргийн командлал Солонгос даяар өрнөж эхлээд байсан ардын ардчилсан хувьсгалын үйл явцыг өөрийн хяналтад байсан өмнөд хэсэгт хүчээр саатуулан тасалдуулахад чиглэсэн үйл ажиллагаа явуулж, дотоодын харгис хүчийг дэмжих талаар 1948 оны тавдугаар сард Солонгосын зөвхөн өмнөд хэсэгт «сонгууль» явуулж улмаар мөн оны найм дугаар сарын 15-нд Бүгд Найрамдах Солонгос Улс гэгчийг зарласан юм.

Ийнхүү АНУ болон түүний шууд дэмжлэгийг авч байсан дотоодын харгис хүчний үйл ажиллагааны уршгаар Солонгос орон хуваагдсан билээ. Солонгосыг хуваагдмал орон болгоход чиглэсэн дээрх алхмын хариуд тус орны умард болон өмнөд хэсгийн дэвшилт, хувьсгалч хүчнүүд Солонгосын Ардын Дээд Хурлыг сонгох бүх нийтийн сонгуулийг 1948 оны наймдугаар сард бүх орон даяар зохион явуулсан. Ингэхдээ умард хэсэгт шууд санал хураах хэлбэрээр, өмнөд хэсэгт нууцаар гарын үсэг цуглуулах шууд бус хэлбэрээр сонгуулийг зохион явуулж Ардын Дээд Хурлыг сонгосон бөгөөд түүний Пхеньян хотноо болсон анхдугаар чуулганаас 1948 оны есдүгээр сарын 9-нд БНАСАУ байгуулсныг тун хаглан зарлав. Эрх чөлөө тусгаар тогтнолынхоо төлөө Солонгосын ард түмнээс харийн түрэмгийлэгчдийн эсрэг явуулсан урт удаан хугацааны тэмцлийн үр дүнд Солонгосын түүхэнд ажилчин тариачны анхны Бүгд Найрамдах Улс ийнхүү байгуулагдсан нь Алс Дорнодод социализмын байр суурийг бэхжүүлэхэд чухал ач холбогдолтой үйл явдал болсон юм.

ЗХУ, БНАСАУ-ыг хамгийн түрүүнд хүлээн зөвшөөрч, 1948 оны аравдугаар сарын 12-нд дипломат харилцаа тогтоож, мөн оны эцсээр тэндээс цэргээ гаргасан юм. Харин БНАСАУ-ыг АНУ хүлээн зөвшөөрөөгүйгээр барахгүй Өмнөд Солонгосоос цэргээ өнөө хүртэл гаргаагүй байна.

Зөвлөлтийн цэргийн командлалын хяналтад оршиж байсан Солонгосын умард хэсэгт ардын ардчилсан хувьсгал эрчимтэй өрнөж 1946 онд Солонгосын Коммунист Нам, Ардын шинэ намтай нэгдэж Солонгосын хөдөлмөрийн намыг байгуулсан бөгөөд үйлдвэрчин, залуучууд, эмэгтэйчүүд, тариачдын зэрэг олон нийтийн ардчилсан байгууллагууд үүсч бүрэлдлээ.

1945—1948 онд Солонгосын умард хэсэгт газрын шинэтгэл явагдаж газар эзэмших, түрээслэх системийг бүрмөсөн устгасан бөгөөд аж үйлд вэрийн газруудыг улсын болгосноор үйлдвэрлэлийн бүх хэрэгслийн 80 хувь нь улсын мэдэлд шилжсэн байв. Эдгээр хувьсгалт ардчилсан өөрч лөлтүүдийн дүнд Солонгосын умард хэсэгт феодализм болон колонишло лын үлдэгдэл үндсэндээ устаж, социализмын үндсийг тавих үед ааж маар шилжих нөхцөл бүрэлдсэн юм.

Солонгосын умард хэсэг дэх ардын ардчилсан хувьсгалын өрнөлт нь Солонгосын дотоодын харгис хүч болон энэ бүс нутагт байр сууриа бэх жүүлэхийг санаархаж байсан АНУ-ын эрх ашигт харшилж байв. Иймээс Өмнөд Солонгос АНУ-ын шууд оролцоотойгоор Солонгосын умард хэ сэгт хөрөнгөтөн, газрын эздийн ноёрхлыг сэргээн тогтоох зорилгоор 1950 оны зургаадугаар сарын 25-нд БНАСАУ-ын эсрэг түрэмгий дайн дэгдээсэн юм. Гэвч БНАСАУ-ын ард түмэн, зэвсэгт хүчин ЗХУ болон социалист бусад орон, дэлхийн дэвшилт бүх хүчний интернационалч тусламж дэмжлэгт тулгуурлан улс орныхоо эрх чөлөө, тусгаар тогтнолоо хамгаалсан юм. Үүний үр дүнд болон дэлхийн олон нийтийн шаардла-

гын нөлөөгөөр түрэмгийлэгчид Солонгосын хойгт дайны галыг зогсоох тухай хэлэлцээрт 1953 оны долдугаар сарын 27-нд аргагүй эрхэнд гарын үсэг зурсан юм. Гэтэл АНУ 1953 оны аравдугаар сарын 1-нд Өмнөд Солонгостой «Хамтын батлан хамгаалалтын Гэрээ» гэгчийг байгуулснаар өөрийн цэргийг тэнд байнга байрлуулах эрхтэй болжээ.

Өнөөдөр Өмнөд Солонгост АНУ-ын цэргийн зөвхөн томоохонд тооцогдох 40 бааз байгаа бөгөөд тэдгээрт 48 мянга гаруй цэрэг, офицер, цэргийн мэргэжилтнүүд, 1000 гаруй цөмийн цэнэг байрлаж байна. Ийм түгшүүртэй нөхцөлд БНАСАУ социалист нийгмийг цогцлон байгуулж байна. Өнгөрсөн 40 жилийн дотор БНАСАУ колонийн хоцрогдсон орноос аж үйлдвэр-хөдөө аж ахуйн социалист улс болон хувирч одоо СХН-ын VI их хурлын шийдвэрийг хэрэгжүүлэх үйлсдээ гялалзсан амжилт олсоор байна.

БНАСАУ-ын эдийн засгийн гол салбар нь аж үйлдвэр бөгөөд энэ нь олборлох, хар болон өнгөт металл, эрчим хүч, нүүрс, хими, нэхмэл, барилгын материал, гэр ахуйн болон аж үйлдвэрийн зориулалттай цахилгаан хэрэгсэл, хөлөг онгоц, төрөл бүрийн авто болон суурь машин, хөнгөн ба хүнсний зэрэг үйлдвэрийн салбаруудтай. Тэдгээрийн дотроос хамгийн эрчимтэй хөгжиж байгаа нь металл боловсруулах болон машины үйлдвэрийн салбар юм. Колонийн дарлалын жилүүдэд энэ салбар нь металл боловсруулах жижиг заводууд болон засварын газруудаас бүрдэж байсан бол өнөөдөр металл зүсэгч болон нарийн ажиллагаатай бусад зориулалтын янз бүрийн суурь машинууд, 2,5—40 тонны даацтай ачааны машинууд, гинжит болон дугуйт трактор, илчит болон цахилгаан галт тэрэг, вагон, 20—50 мянган тонны даацтай загас агнуурын болон тээврийн усан онгоцууд, өргөгч цамхаг, дотоод шаталтын хөдөлгүүр, генератор, трансформатор, компрессор, насос зэргийг үйлдвэрлэж байна. Мөн хөргөгч, телевизор зэрэг гэр ахуйн болон аж үйлдвэрийн зориулалттай цахилгаан хэрэгслийн үйлдвэр хөгжиж байна.

Одоо БНАСАУ-д хэд хэдэн томоохон үйлдвэрийн газрууд баригдаж байна. Үүнд Сунчхоны виналоны үйлдвэр, Саривоны калийн бордооны үйлдвэр зэргийг нэрлэж болно. Удахгүй ашиглалтад орох Сунчхоны виналоны үйлдвэр нь жилд 1 сая тонн карбит кальци, 750 мянган тонн мета нол, 100 мянган тонн виналон, 900 мянган тонн азотын бордоо, 250 мянган тонн каустик болон 400 мянган тонн кальцийн сод, 300 мянган тонн уурагт тэжээл үйлдвэрлэх юм. Саривоны калийн бордооны үйлдвэр нь жилд 3 сая калийн хүдэр боловсруулж, 510 мянган тонн калийн бордоо, 10 сая тонн цемент үйлдвэрлэх хүчин чадалтай юм. Энэ үйлдвэр ашиглалтад орсноор БНАСАУ калийн бордооныхоо дотоодын хэрэгцээг бүрэн хангах болно.

БНАСАУ-ын хөдөө аж ахуйн гол салбар нь газар тариалан юм. Уулархаг орон учир нутгийн зөвхөн 16 хувь буюу 2 сая орчим га талбайг боловсруулж, тариаланд ашигладаг. Олонх талбайгаас жилд хоёр удаа ургац авдаг. Бүх талбайн 3-т цагаан будаа, 1/5-д техникийн ургамал, үлдсэн хэсэгт нь төмс, хүнсний ногоо, алим жимс, улаан буудай, шар буурцаг, арвай, хөвөнгийн ургамал, чихрийн нишэнгэ, тамхи, хүн орхоодой тариалдаг.

БНАСАУ нь торгоны болон ойн аж ахуйгаас гадна мал аж ахуйг хөгжүүлж байна. БНАСАУ хөгжлийнхөө 40 жилийн явцад ардын боловс ролын салбарт онцгой амжилт олж 1972 оноос бүх нийтийг 11 жилийн боловсролтой болгох зорилтыг хэрэгжүүлж байна.

Үүний зэрэгцээ соёл, шинжлэх ухаан, эрүүлийг хамгаалах салбар амжилттай хөгжиж байна.

БНАСАУ 1989 онд болох Дэлхийн залуучууд оюутны XIII их наадмыг зохион байгуулах санаачилга гарган бэлтгэл ажлыг амжилттай хийж байна. Их наадамд зориулж «Кванбоккийн хороолол» нэртэй иж бүрэн комплекс барьж байна. 4 сая ам метр талбай дээр 200 орчим төрөл бүрийн барилга байгууламж (спортын 4 ордон, 2 стадион, үйлчилгээний төвүүд, бассейн, дунджаар 100 орчим ам метр талбайтай 20 мянган айлын сууц г.м) баригдаж байна.

БНАСАУ олон улсын тавцан дээр марксизм-ленинизм, пролетарийн интернационализмын зарчмыг удирдлага болгосон энх тайванч гадаад бодлого явуулж, социалист хамтын нөхөрлөлийн орнуудтай найрамдал, нэгдэл нягтралыг бэхжүүлэхийн төлөв байдаг бөгөөд тэдэнтэй улс төр, эдийн засаг, соёлын өргөн харилцаа, хамтын ажиллагаа тогтоон хөгжүүлж байна. БНАСАУ даян дэлхийд, түүний дотор Алс Дорнодод энх тайвныг сахин хамгаалж бэхжүүлэх эх орноо энх тайвнаар ардчилсан үндсэн дээр нэгтгэх замаар Солонгосын хойгт энх амгалан байдал тогтоохын төлөө тууштай тэмцэж, олон чухал санал санаачилга дэвшүүлж ирснийг дэлхийн олон нийт сайн мэддэг юм. Үндэсний эвлэрлийн бодлогын үндсэн дээр Солонгосын хойгийн өнөөгийн асуудлыг зохицуулж уг бүс нутгийг цөмийн зэвсэггүй бүс болгож, хойгийн өмнөд хэсгээс америкийн цэргийг гаргаж, яриа хэлэлцээгээ амжилтанд хүргэх талаар гаргаж буй БНАСАУ-ын засгийн газрын чармайлтыг БНАСАУ-ын ард түмэн, засгийн газар бүх талаар дэмжиж байна.

Манай улс БНАСАУ-тай 1948 оны аравдугаар сарын 15-нд дипломат харилцаа тогтоосон бөгөөд ЗХУ-ын дараа БНАСАУ-ын тусгаар тогтнолыг хүлээн зөвшөөрсөн хоёр дахь орон юм. БНАСАУ-ын эсрэг АНУ болон Өмнөд Солонгосын өдүүлсэн түрэмгий дайны жилүүдэд (1950-1953) монгол, Солонгосын ард түмний найрамдалт харилцаа улам батжин бэхэжсэн юм. Дайны болон БНАСАУ-ын сэргээн босголтын жилүүдэд манай улс ах дүү социалист бусад орны нэг адил Солонгосын ард түмний тэмцлийг тууштай дэмжиж, хэр чинээний эд материалын тусламж үзүүлж байв.

1951—1957 онд манай улс солонгосын ард түмэнд 226 мянга гаруй толгой мал, 5 мянган тонн улаан буудай, 7,3 мянган тонн мах болон хүнсний бүтээгдэхүүн, 120 мянга гаруй ширхэг төрөл бүрийн хувцас бэлэг болгон өгчээ. Мөн эцэг, эх нь дайнд амь үрэгдэж өнчирсэн солонгосын 200 хүүхдийг 1952—1959 онд асран хүмүүжүүлж солонгосын 30 гаруй оюутныг өөрийн их, дээд сургуулиудад үнэ төлбөргүй суралцуулж байлаа.

1961 онд БНАСАУ өөрийн хүч хөрөнгөөр монгол солонгосын найрамдлын нэрэмжит Төв аймгийн Алтанбулаг сумын «Хөдөлмөр» нэгдэлд сурагчдын дотуур байр, гуанз бүхий дунд сургуулийн байр барьж өгсөн юм. 1988 оны тавдугаар сард уг дунд сургуульд хими, физикийн лабораторийн тоног төхөөрөмж, биологийн кабинетын янз бүрийн үзүүлэн бэлэглэсэн юм.

МАХН-ын Төв Хорооны ерөнхий нарийн бичгийн дарга, БНМАУ ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн дарга нөхөр Ж. Батмөнх тэргүүтэй манай нам, төрийн төлөөлөгчид 1986 онд БНАСАУ-д айлчилж, БНМАУ, БНАСАУ-ын хоорондын найрамдал, хамтын ажиллагааны тухай гэрээ байгуулсан нь хоёр орны хамтын ажиллагааны харилцааг бүх талаар өргөтгөн хөгжүүлэх, шинэ шатанд гаргах чухал үндсийг тавьж,

монгол, солонгосын ард түмэн бие биеийн ололт амжилт, социалист бүтээн байгуулалтын туршлагатай өргөн танилцаж нягт хамтран ажиллах сайхан төлөвийг нээсэн юм. Өнөөдөр БНМАУ, БНАСАУ-ын харилцаа улс төр, эдийн засаг, соёл, шинжлэх ухааны салбаруудыг хамран бүх талаар өргөжиж байна.

Хоёр орны харилцаанд гадаад худалдаа чухал байр суурь эзэлдэг юм. БНМАУ, БНАСАУ-ын хоорондын 1986—1990 оны худалдааны удаан хугацааны хэлэлцээрийн дагуу нийт бараа гүйлгээ өмнөх таван жилийнхээс 54,4 хувь өснө. Манай улс БНАСАУ-аас цагаан будаа, алим, өргөн хэрэгцээний зарим бараа, арьс шир идээлэх химийн бодис, цахилгаан дамжуулах утас зэрэг барааг худалдан авч, хонины халуун угаалгын ноос, хурганы ноос, улаан буудай, хаягдал төмөр, хөнгөн цагаан зэргийг худалдаж байна.

1960 оны нэгдүгээр сард БНМАУ, БНАСАУ-ын хооронд байгуулсан шинжлэх ухаан—техникийн талаар хамтран ажиллах тухай хэлэлцээжийн дагуу хоёр талын комиссыг байгуулсан юм. Өнгөрсөн хугацаанд ШУТ-ийн талаар хамтран ажиллах монгол, Солонгосын комисс 16 удаа хуралдав. ШУТ-ийн хамтын ажиллагаа туршлага судлах, мэргэжилтэн харилцан илгээх, техникийн баримт бичиг, загвар, ургамлын үр, эмийн ургамлын каталог солилцох зэрэг уламжлалт хэлбэрээс гадна сүүлийн үед хөнгөн, хүнсний үйлдвэр, нийтийн аж ахуй үйлчилгээний салбарт хамтран ажиллах, туршлага солилцох, тайзны засал, гэрэл чимэглэлийн асуудлаар туршлага судлах зэрэг шинэ хэлбэрээр баяжиж байна.

1988 оны зургаадугаар сарын 28-наас долоодугаар сарын 1-нд СХН-ын Төв Хорооны ерөнхий нарийн бичгийн дарга, БНАСАУ-ын ерөнхийлөгч нөхөр Ким Ир Сен манай оронд албан ёсны найрсаг айлчлал хийсэн нь монгол, Солонгосын харилцаанд чухал үйл явдал болов. Уг айлчлалын үеэр эдийн засаг, шинжлэх ухаан-техникийн салбарт хамтран ажиллах БНМАУ, БНАСАУ-ын засгийн газар хоорондын зөвлөлдөх Комисс байгуулах тухай хэлэлцээр байгуулсан нь манай хоёр орны эдийн засгийн хамтын ажиллагааг өргөтгөж, түүний үр өгөөжийг дээшлүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэх юм.

1988 оны 10 дугаар сарын эцсээр БНМАУ-ын Шинжлэх Ухааны Академийн ерөнхийлөгч Н. Содном тэргүүтэй төлөөлөгчид БНАСАУ-д айлчлах үеэр БНМАУ-ын Шинжлэх Ухааны Академи, БНАСАУ-ын Байгалийн шинжлэх ухааны академийн хооронд хамтран ажиллах тухай хэлэлцээр, 1989-1990 оны хамтын ажиллагааны төлөвлөгөөнд Н. Содном, Ким Ген Бон нар гарын үсэг зурав. Нөхөр Содномыг СХН-ын Төв Хорооны Улс төрийн товчооны гишүүн, БНАСАУ-ын Засаг захиргааны зөвлөлийн ерөнхий сайд Ли Тен Мо хүлээн авч уулзлаа.

БНМАУ, БНАСАУ-ын академиудын хооронд ийнхүү хэлэлцээр байгуулагдсан нь тус хоёр орон шинжлэх ухаан, техникийн талбарт улам ягт хамтран ажиллах өргөн бололцоо нээж өгч байна.

Ийнхүү Монгол-Солонгосын ард түмний найрамдалт харилцаа өдрөөс өдөрт гүнзгийрэн хөгжиж, агуулга хэлбэр нь улам баяжиж байна.